

ЭРДЭНЭ ЗУУ ХИЙДИЙН ТҮҮХИЙН ЗАРИМ АСУУДЛЫГ ХӨНДӨХИЙН УЧИР

Харнууд З.Лонжид

Өгүүллийн товч: Монголын буддизмын түүхэнд олонтаа тэмдэглэсэн Эрдэнэ-Зуу хийдийн тухай судалгааг тодруулахад анхаарч үзүүштэй зарим зүйлийг энэхүү өгүүлэлд авч үзлээ.

Түлхүүр үг: Жамбадорж, Абтай, Далай лам, Галдан Дугарравдан, Өгөөмөр Цагаан Сүүл, Бумбат.

Судлаачдын олж тогтоосноос үзвэл ХХ зууны эхэн үед одоогийн Монгол Улсын нутаг дэвсгэрт 2648 хүрээ хийд, мөргөлийн газар (**Коростовец.73**) байсан бөгөөд тэдгээрийн ихэнх нь өөрийнхөө үүсэл, дэг жаягийг он цагийн дарааллаар өгүүлсэн бичмэл түүхтэй бөгөөд түүнийгээ үе үе баяжуулан шинэчилж, хойч үеийнхэндээ дамжуулан үлдээдэг тогтсон уламжлалтай байв. Гэвч цөвүүн цагийн их эрсдэл тохиосон үед тэдгээр олон хүрээ хийдийн үүх түүхийн ихэнх нь үгүй болжээ. Гэвч зарим нэгэн том, жижиг хийдийн түүх бараг бүрнээрээ үлдэн хоцорчээ. Тухайлбал, Эрдэнэ зуу хийдийн түүхийн хэд хэдэн хувилбар бидний үед хүрч ирснийг судлаачид анхааран шинжилж бүтээл туурвилдаа тулгуур хэрэглэхүүн болгон ашиглаж байна. Харин Эрдэнэ зуугийн түүхийн бүх эх ба хуулбарыг тэр хэвээр нь факсимиле-ээр хэвлэж олны хүртээл болгох нь тун хэрэгтэй байгааг энэ дашрамд тэмдэглэж байна.

Монголын ба харь улсын эрдэмтэд, түүхчид, жуулчин олон хүн Эрдэнэ зуу хийдийн тухай өөрсдийн бүтээл туурвилдаа ямар нэгэн байдлаар өгүүлсэн байдаг. Тэдгээр бүтээлийг ерөнхийд нь дөрвөн том чиглэлд хувааж болох юм. Тухайлбал **Нэгдүгээрт**, уг хийдийн үүсэл буюу анх хэзээ ямар учир шалтгааны улмаас Эрдэнэ зуу хийдийг байгуулах болсон тухай асуудлыг тодруулахад анхаарсан байна. **Хоёрдугаарт**, уг хийдээс бурхан шашны талаар явуулсан үйл ажиллагааг нэхэн судлахад чиглэсэн байна. **Гуравдугаарт**, 1586 оноос эхлэн тус хийдэд буюу түүний нутаг дэвсгэрт болсон үйл явдлыг тодруулжээ. **Дөрөвдүгээрт**, нилээд түүхчид Эрдэнэ зуу хийдийн сүм, дуган, хэрэм барилгын ур хийц донж маяг, болон тус хийдийн хуучирч элсэн сүм дуган дацангийн барилга байшин хэзээ барьсан засаж сэлбэсэн тухай өгүүлжээ. Эрдэнэ зуу хийдийн түүхийг шинжилсэн олон судлаачдын ихэнх нь гол гол асуудлаар санал ойролцоо байдаг боловч хааяа зөрүүтэй зарим зүйл бий. Тухайлбал, Эрдэнэ зуу хийдийг анх санаачлан бариулсан хүн бол Халхын Абтай хэмээн олон судлаач ямар ч эргэлзээгүйгээр итгэдэг бол Урадын түүхч Жамбадорж **"Эрдэнэ зууг бүтээдэг ноён бол Очирбат түшээт хан бололтой"** (Жамбадорж.468) гэж бичсэн нь чухам Абтай сайн хан мөн эсэхэд эргэлзсэн мэт. Жамбадорж Эрдэнэ зууг хэдэн онд байгуулсан тухай чимээгүй өнгөрчээ. Тус хийдийг байгуулсан оныг олон судлаач 1586 он гэж үздэг боловч зарим нь хөхөгчин тахиа жил 1585 онд буюу Абтай хан Далай ламтай уулзахаасаа нэг жилийн өмнө Шунхат уулын ар дахь хуучин балгасанд сүмийн үйлийг эхэлсэн гэж бичээд (Шамба.77-78) гал нохой жил (1586) Абтай Түмэд нутагт морилж, Далай ламтай учирч номын их Очир хаан цол хүртсэн гэжээ. Энэ мэдээг (1585 он гэдэг) хуучин ЗХУ-ын түүхчид ч бас дэмждэг. (7.587). Бас зарим түүхч 1589 онд Эрдэнэ зуу байгуулагдсан гэж бичдэг. (Диеэ Ж. Харлоу.166.Монгол.1043) "Хятадын түүхчид ийнхүү 1589 онд гэж бичсэн нь арай л ташаа мэт байдаг. Тухайлбал түүхчдийн бичсэнээс үзэхэд Абтай хан 1544 онд төрж, 1588 онд таалал болсныг ч анзаарууштай.

Харин 1585 онд буюу хөхөгчин нохой жил тус хийдийг барьж эхэлсэн гэдэг нь үнэмшилтэй байж магадгүй. Яагаад гэвэл Шамба Асрагч нэртийн түүхийг 1677 онд

бичихдээ нилээд ултай хэрэглэхүүн ашигласан нь лавтай. Нөгөө талаар Монгол нутагт шарын шашин дэлгэрүүлэхэд Түмэдийн Алтан хан ихээхэн анхаарч санаа тавьж 1578 оны зуны дунд арын 15-нд Далай ламтай анх золгож ном сонсож багш шавийн барилдлага тогтоосныхоо дараахан 1580 онд Хөх хотод шарын шашны сүм "Их зуу"-г цогцлоож байлаа. Мөн 1585 онд Харчины алдарт гүүш Аюуш гуравдугаар Далай ламын дуртган зарлиг болосны дагууд түвэд үгийн аялгууг монголчуудад аль болохоор зөв дуудаж сурахад дөм болгож Али галийн үсэг буюу гадаад үгийг тэмдэглэх галиг (транскрипц) зохиов. Ийхүү буддизмыг дэмжигчид олширч байх үед Абтай хан 4 жилийн дараа буюу хөхөпин тахиа жил 1585 онд Эрдэнэ зуугийн эх үүсвэрийг тавьсан байж тун магадгүй. Иймээс ч зарим судлаачид 1585 онд Эрдэнэ зуу хийдийн анхны байгууламж гол зуугийн сүмийг ч барьж эхлэв гэж үзэж байна (Хатанбаатар. 218)

Ойрадын Зүүн гарын цэрэг хэдэн удаа Эрдэнэ зууд орсон тухай түүхчид төдий л санал нийлцэггүй учир энэ тухай товч ярьж. 1688 оны тавдугаар сарын дундуур Галдан бошогт хаан Данжил, Данзан-Омбо, Дугарравдан, Цэвээнравдан, Ану хатан нар 30000 илүү ойрад цэрэг дагуулж Ховдын баруун хойд этгээдээс Халхыг зорин хөдөлж замдаа Засагт ханы Үйзэн хатанбаатар, Сэцэн ноён нарын харьяатыг, довтлон цохиод Дармашир ноёны харьяатаас олон эрсийг өөртөө дагуулахад баруун гарын хотогойдын хунтайж Лувсангийн дүү хатан Эрдэнэ хун тайж Галдангаас айж Сэлэнгэ рүү зугадан дүрвэсэн байна. Ингэж Галдангийн цэрэг зам зуураа бараг сааталгүй явсаар Түшээт ханы нутагт ороход тус тус нутагт зарим ноёд тухайлбал хөндлөн бошогт ноён харьяат нараа авч зүүн зүг Хөлөн нуурлуу зугадсан аж. Галдан хэд хэдэн чиглэлд элч мордуулан Чихундорж Жибзундамба хоёрын хаа байгааг олж мэдэхийг оролдсон байна. Чихундорж ч ойрад цэрэг ирж байгааг сонсож мэдээд мөн оны (1688) зургадугаар сарын 12-ны өдөр тусгай гүн зарж Жибзундамбын дэргэд очуулж цэрэг хөдөлгөн Галдантай дайтахад тусал хэмээн хэлүүлжээ.

Энэ дагуу Жибзундамба Сэлэнгэ мөрнөөс Чихундоржийн ууган хөвгүүн Галдандоржийн 5000 гаруй цэргийг дуудан ирүүлж Данзан ламын ач шударга эрх дайчин Шамба-ын харьяат 5000 цэрэгтэй нэгтгэж, Чихундоржид туслуулахаар мордуулжээ. Галдандорж Шамба нарын цэрэг Чихундоржид туслахаар явах замдаа Төмөр гэдэг газар хүрч Галдагийн цэрэгтэй гэнэт тулгарч ширүүн дайтсан боловч Галдандорж өөрийн цэргээс 300(300) гаруй хүний дагуулж Онги гол руу зугадан Цахиртай гэдэг газар очсон байна. Зарим мэдээгээр бол 1688 оны тавдугаар сард Галдангийн дүү Доржжав 400 цэрэг авч Түшээ ханы нутагт орж ирэхэд Түшээт ханы хүү Галдандорж угтан байлдан Доржжавыг алсан байна. Энэ явдалд ихээхэн уурсаж хорссон Галдан бошогт их цэргээр Эрдэнэ зууг довтолгон эзэлж шатаасан байна.

Харин Жибзундамба Галданг Эрдэнэ зууд ирэхээс өмнө Чихундоржийн гэр бүлийнхний бусад хүмүүстэй авч Сэцэн ханы нутагт оржээ. Халхын нас барсан сэцэн хан Илдэн Равданд Энх-Амгалан хааны зарлигаар буян хүргүүлэхээр зарсан элч хиа Ананд туслагч түшиг Хэшиг нар энэ тухай мэдээг Энх-Амгалан хаанд хүргэсэн гэжээ. (Биеэр.69) Галдан ч Жибзундамба хутагт Эрдэнэ зууд байсныг олж мэдээд Данжин-Омбо, Дугарравда нарт 7000 цэрэг өгч Хар Зоргон гэдэг газраас хөдөлж Эрдэнэ зууг довтолуулахаар илгээжээ. Галдан өөрөө ойрадын цэргийн гол хүчийг захирч Туулыг гаталж Хэрэнг чиглэж Сэцэн хан Илдэн Равдангийн хүү Өмөхэйг баривчлахаар хөдөлсөн байна. Данжин-Омбо Дугарравдан нар Эрдэнэ зуу руу ирж явааг Жибзундамба сонсоод Түшээт хан хатан, үр хүүхэд, лам хар 300-гаад хүн дагуулж Сэцэн ханы нутаг Өгөөмөрт дутаан хүрч түр амсхийгээд Чихундоржид туслах хүч илгээхээр оролдсон боловч чадалгүй улмаар зүүн өмнө чиглэн явж Авга нарын хошууны хилийн дэс хүрч буудаллажээ. Данжин-Омбо Дугар Равдан нарын их цэрэг Эрдэнэ зуу орсон боловч Жибзундамыг баривчилж чадаагүй учир сүм хийд, ном судрыг шатаажээ. Галдангийн

(Анхны үзэл)
1688 онд Галданг хэрэг
1688 онд Галданг хэрэг
1688 онд Галданг хэрэг

цэрэг Хэрлэнг гаталж байх үед сэцэн хан Илдэн Равдан нас нөгчиж түүний хүү Өмөхэй авга ах Нанжилтайгаа зүүн өмнө тийш явж Үзэмчиний хилд нэвтэрчээ.

Галдан сэцэн ханыхныг гүйцээгүй боловч Чахундорж Түшээт хан аймагтаа байгаа гэдгийг сонсоод баруун зүг буцсан байна. Их хүчний өмнөөс олон хоног дайтсан Чахундорж яаралтай элч зарж Бээжинд илгээж цэрэг ирүүлж ойрадын эсрэг дайтахад туслахыг хүсэхэд Энх-Амгалан хаан 1688 оны долдугаар сард тэргүүн зэргийн хиа Ананд, лам Шиннэндорж Сангийн хэргийн яамны ялгагч түшмэл Шар нарыг Галдан бошогт руу зарж Халхтай дайтахаа зогсоохыг ятгуулахаар зарлиг буулгасан байна.

Гэвч Энх-Амгалангийн элч нарыг Галдантай уулзахаар явж байх үед Галдан бошогт Түшээт ханы нутагт очиж Чахундоржтой дайтаж эхэлсэн байв. 1688 оны наймдугаар сарын 6-нд хоёр талын цэрэг Олгой нуурт гурван өдөр завсаргүй тулалдаж гуравдахь өдрийн орой Ойрадын цэрэг халхын Шамба эрх дайчингийн цэргийг их хүчээр дайрч сарниулсан ба Чахундоржийн цэрэг тал тал тийшээ тарж Чихундорж хэсэг харьяатаа авч Сөнид рүү одсон байна.

1729 оны намар Зүүн гарын Галданцэрэн олон түшмэл зайсангуудаа зарлан цуглуулж "Заргын зөвлөлгөөн" гэгчийг хуралдуулж Манжийн эсрэг тэмцэхдээ юуны өмнө Халхын II богдыг олзолж авах юм бол бүх халх аяндаа Зүүн гарыг дагах болно гэж тохирцгоон бага Цэрэндондовыг гурван түмэн цэрэгтэй Халх руу илгээхээр шийдвэрлэжээ. Бага Цэрэндондовын гол зорилго нь Эрдэнэ зууг дайлж II богдыг уулгалан авахад чиглэжээ.

Ойрадууд ийнхүү Халхыг довтолж II Богдыг олзлох бэлтгэл хийж байх үед буюу 1731 оны есдүгээр сард Найралт төв хаан зарлиг буулгаж Жибзундамбыг Эрдэнэ зуугаас Өвөр Монголын Долон нуурт шилжүүлсэн байна. Гэвч Зүүн гарынхан үүнийг мэдээгүй учир 1732 оны зургадугаар сард бага Цэрэндондов Галданцэрэнгийн зарлигаар бүх цэргээ тус бүр 15000 цэрэгтэй хоёр зам хувааж хар Эрчисийн ар Хяраас Булган гол Хотон хорхоор дамжин алсын аяндаа мордож Халхаас Ойрадад дагаж ороод байсан Бэж гүн, бэйс Муухай Дашдаржаа нараар замчлуулан Ховдыг өнгөрч Дөргөн нуурыг тойрч Цагаан Сүүлд байсан Манж Чин Улсын их цэргийн баруун хэсэг байрласан Усан зүйлд очиж хоёр замын их цэргээ нийлүүлж түр буудаллахад нь Цагаан Сүүлд түр ирээд байсан Хязгаар дахиныг төвшитгэх их жанжин Ши Бүү 3000 цэрэг авч бага Цэрэндондовын цэрэг рүү довтолсон боловч ялагдаж буцахад нь Зүүн гарын цэрэг Хангайн нурууны араар зүүн зүг явж Цагаан Сүүлийн чанх хойно орших Хэрсэн чулуу хүрэхэд Эфү Цэрэн жанжин Мардай Чин ван Данжиндорж нар Чин улсын 10000 арай хүрэхгүй цэргээр бага Цэрэндондовыг тосон ширүүн дайтжээ. Гэтэл чин ван Данжиндорж хэдэн өдрийн дараа захирсан цэргээ авч галын шугамаас буруулан оджээ. Энэ үед Цагаан Сүүлд байсан их жанжин Ши Бүү эфү Цэрэн Зүүн гарын цэрэгтэй хоёр өдөр тулалдаад бут цохиулан ухарсан байна.

Үүний дараа бага Цэрэндондов Хэрсэн чулуунаас мордож Идэр голыг өнгөрч урагц чиглэн явж шууд Эрдэнэ зууд орсон боловч II богд байгаагүй учир баруун зүг буцсан байна. Энэ үед Цагаан Сүүлийн их цэргийн Жанжин Ши Бүү зарлиг буулгаж, Эфү Цэрэнд олон цэрэг захируулж Бумбатын даваа руу илгээж бага Цэрэндондовын цэргийг амдаж устгахыг даалгажээ. Гэтэл үүнийг бага Цэрэндондовын тагнуул олж мэдсэн учир шууд явж Тамир голын Хөвөөнд байсан эфү Цэрэнгийн орд өргөөнд очиж охид, хөвгүүд адуу малыг нь уулгалсан байна. Энэ тухай мэдээг Бумбатын даваанд ойрадын цэргийг угтан тосож байсан эфү Цэрэн сонсоод ихэд хилигнэж гэзгээ хяргаж мориныхоо сүүлийг хайчлаад Зүүн гарын цэрэгтэй эрэгчин, эмэгчнээ үзэхээр ам тангараг тавьж тэнгэрт залбиран 20 мянган цэрэг авч бага Цэрэндондовын цэргийг нэхэн хөөсөөр 1732 оны наймдугаар сарын 5-ны өдөр үүр цайхаас өмнөхөн Хар сэнж нуурын дэргэд байрласан Ойрад цэргийн хуаранг олж шууд дайран довтолж эхэлсний сацуу чин ван Данжиндорж руу элч илгээж зүүн гарын цэргээ ирүүлж туслахыг тушаасан байна. Данжиндорж уг мэдээг авсан боловч эфү Цэрэнд

туслах цэрэг илгээгээгүй тул гэнэтийн довтолгоонд өртсөн ойрад цэрэг эсэргүүцэн байлдсан боловч зүг ухарсаар дахин Эрдэнэ зууд хүрч хоёр өдрийн турш Манжийн цэрэгтэй маш ширүүн тулалдаж байгаад чин ван Данжиндоржийн цэрэг эфү Цэрэнд туслахаар ирвэл бүх цэргийн хамт олзлогдоход хүрч болзошгүй хэмээн болгоомжилж Орхон голын эх өөд ухарчээ. Гэвч эфү Цэрэндондов араас нь салалгүй нэхэн байлдсаар Зүүн гарын цэргийн 10000 орчмыг нь алж шархдуулжээ. Бага Цэрэндондов үлдсэн 20000 цэргээ авч Орхоны эхээс хөдөлж Түй голыг өнгөрч Загбайдрагийн голын бэлчир хавиар өнгөрөхдөө их гал тавьсны улмаас Эфү Цэрэнгийн цэрэг түймэр дундуур гатлах аргагүй болжээ. Заг Байдрагийн орчим байрлаж байсан Манж цэргийн томоохон хүрээнийхэн бага Цэрэндондовын цэрэг зүүн талаас дутаан ирж байгааг мэдсэн боловч тэднийг тосон байлдахаас эмээж нам жим өнгөрүүлсэн байна. Дээр өгүүлснээс үзвэл Зүүн гарын цэрэг зөвхөн 1732 оны зун намар хоёр удаа Эрэдэнэ зууд орсон нь тодорхой байна. Гэхдээ чухам ямар үр дагавар учруулсныг түүхчид төдий л тодруулж амжаагүй өдий хүрснийг цаашид гүнзгийрүүлэх хэрэгтэй байна. Жич, Ойрадын цэрэг 1688 оноос хойш гурван удаа Эрдэнэ зууг довтлон галдаж түймэрдсэн гэж түүхчид бичдэг боловч тэд "Эрдэнэ зуугийн шүтээнд халдаж эвдлэн сүйтгэж ариун дагшин бурхдаас нь хулгайлсан" гэж И.Я.Коростовец 1920-иод онд бичсэнийг тун анзаарууштай төдийгүй цааш нь нэхэн тодруулах нь чухал байна. Бодоход И.Я.Коростовец манж хятад сурвалжид тулгуурлаж ингэж бичсэн байх. Түүнээс бус санаанаасаа зохиогоогүй буй за (Коростовец.40)

Монголын түүхнээ зохих учир холбогдолтой цөөнгүй үйл явдал Эрдэнэ зууд буюу түүний орчимд болсон тухай үүвэр түүвэр мэдээ байдгийг ултай судалж үзүүштэй атал түүхчид энэ талаар төдий л анзаарахгүй байдаг бололтой. Жишээлбэл академич Ш.Бира аругай бичихдээ "Өөлэд (ойрад З.Л) Халхын олон жилийн өрсөлдөөн тэмцээнийг амаржуулахын төлөө" Жибзундамба санаа тавьж" 1696 оны үед "цаг лугаа зохилдуулсан залбирал адистадын дээдийг хайрлагч оршибай" хэмээх алдарт бүтээлээ туурвисан гэжээ. (Бира.194-198) Миний санахад Жибзундамба энэ бүтээлээ Эрдэнэ зууд зохиосон байж тун магадгүй.

Мөн Эрдэнэ зуугийн хавьд "Халх журам" хэмээх хуулийн зарим хэсгийг боловсруулсан байж ч болзошгүй. Бас нэг анзаарууштай зүйл гэвэл 1686 онд Занабазар Соёмбо үсгээ ч Эрдэнэ зууд зохиосон байж таармаар. Гэвч үүнийг ултай мөшгөөгүй байна. "Соёмбо үсгийн утгыг нээгч Занабазарын тааллын чимэг орошибай" хэмээх түвэд хэлээр монгол зохиогчийн бичсэн номыг 1930-аад онд судлаач Б.Ринчен Гомбожав арамба гэгч хүнийг гуйж монголчуулсан бөгөөд тэр нь Улсын номын санд байдаг" (Ринчен.175-д үз) гэжээ. Гэтэл энэ ном одоогоор олдохгүй байдаг. Уг нь тэр номоос зарим зүйлийг тодруулж болох юм.

Мөн Эрдэнэ зуугийн бичээч Агваан цорж гэж аман яриа домог өгүүлэлд олонтаа тохиолддог эрдэмтэн байсан бололтой. Гэвч түүний тухай бас л судалж үзээгүй байна. Зарим эрдэмтний бичсэнээр бол Агваан цорж Эрдэнэ зуугаас гадагш хөдөө гадаа явахдаа ном зохиолоо хэлж тэмдэглүүлдэг нэг шавьдаа үргэлж үнсэн самбар өвөртлүүлэн явуулдаг байж. Тэгээд нэг өдөр их үертэй Орхоныг гаталж явтал гэнэт мориныхоо амыг татаж өнөөх бичээч шавиа самбараа бушуухан гарга. Ном шарлаад байна гэхэд нь тэр шавь нь савнаасаа халин үерлэсэн их усан дунд маш сандарч толгой нь эргэн арай хэмээн мориныхоо нуруун дээр тогтож явсан байжээ. Гэвч багш нь шавийнхаа бачимдаж явааг огт бодохгүй морио зогсоогоод дайвалзан урсах их усан дунд самбараа гарга ном шарлаад байна гэж давтан шаардахад өнөөх шавь нь тэсгэлгүй тэвдэхдээ: Багшийн ном яасан шарлаж, харлаж, барлаж дуусдаггүй юм бэ ? гэж хашгирч байсан гэдэг. Ном шарлах гэдэг монголын өвөрмөц хэллэг бол юм бичдэг, боддог, зохиодог хүний сэтгэлд шинэ санаа бодол орж ирэхийг ном шарлана гэдэг ажээ. (8. 176) Бас нэгэн тодруулуштай зүйлийн тухай дурдъя. Юу гэвэл Эрдэнэ зуу хийд байгуулсан газар бол Хар хүрэмийн туурь

байсан гэдгээр санаа амралгүй "Тайхан цайз", "Тайх хад", "Тайхал горхи", "Тахай балгас" "Тайхал шивээ", "Тайхал хороо" гэсэн зургаан нэртэй газрын тухай Юан улсын судар Сударын чуулганд болон Х.Пэрлээ Ц.Дамдинсүрэн Сайшаал зэрэг эрдэмтдийн зохиолд буй мэдээг харьцуулан судлаж тодруулах хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл Эрдэнэ зууг Хар хүрэмийн туурь дээр бус арай өөр газар анх шавыг нь тавьсан байж болзошгүй нягтлууштай, Манж Дайчин улс 1690-ээд оны сүүлчээс 1900-гаад оны эх хүртэл Эрдэнэ зуу хийдийн талаар онцгой анхаарч тусгай дэг журам тогтоосон бололтой. Тиймээс ч түүхэнд мөргөлөөр очих ойрад хүмүүс хэн боловч заавал Хүрээ сайдаас зөвшөөрөл авдаг болсон байна. Иймд үүний учир шалтгаан, үр дагаврыг цаашид тодруулах нь зүйтэй гэж бодож байна.

Жишээлбэл, 1803 онд (Сайшаалт Ерөөлтийн 8-р оны 7-р сард) Дөрвөдийн тайж Цэвэгжав, Төгсжаргал нарын 126 хүн, Торгуудын аранжамба нарын 19 хүн Хүрээ сайдад бичиг өргөж Эрдэнэ зууд очиж мөргөх зөвшөөрөл айлтгасанд тэдний 45-ыг нь бичиг түүхий учир Эрдэнэ зуу орж болохгүй хэмээн буцааж бусдынх нь хүсэлтийг ёсоор болгожээ.

Мөн 1803 оны 8-р сард Дөрвөдийн чуулганы дарга туслагч жанжин бэйл Басагт түүний хөвгүүн тэргүүн зэрэг тайж Гончигжав зэрэг 35 хүн Эрдэнэ зуу орох зөвшөөрөл хүсэж айлтгасан байдаг. Ойрадаас Эрдэнэ зууд мөргөлөөр очигсод хүрээ сайдаас зөвшөөрөл хүсэхдээ хүн тус бүрийн нэр цол хэргэм зэрэг албан тушаалтай эсэхээ тодорхой дурдахын сацуу ачлагын тэмээ, уналгын морь, авчяваа буу саадагныхаа тоог хүртэл нарийн тодорхой дурддаг байжээ. (ҮТА.1-1-3378) Эрдэнэ зуу хийдийн түүхийн судалгаанд шууд ба дам холбогдох атлаа төдий л анзаарагдаагүй байгаа зарим сэдэв асуудлыг хөндөхөд ийм байна.

Эцэст нь тэмдэглэхэд Эрдэнэ зуугийн түүхийг судлан шинжлэх талаар цаашид дорвитой анзаарах зайлшгүй шаардлагатай байна. Яагаад гэдгийг энд тайлбарлан нуршиг нь илүүц. Эрдэнэ зуу судлалд ахиц гаргахын тулд архив болон хувь хүмүүст байгаа янз бүрийн сурвалжийг уйгагүй шүүрдэж үзэх ёстой. Урьд өмнө нь илэрч нуруугийг нь автагч эшилсэн хэдхэн сурвалжаар Эрдэнэ зуугийн түүхийг цаашид баяжуулах буюу үнэнд ойртсогч бүтээл туурвих боломжгүй боллоо. Ялангуяа ҮТА-ийн Хүрээ сайдын сан хөмрөгт Эрдэнэ зуугийн холбогдолтой манж хэлээр бичсэн монгол орчуулгагүй нилээд олон нэгж бий. Тэдгээрийг нэг бүрчлэн үзүүштэй. Мөн Эрдэнэ зуугийн түүхийн хэд хэдэн эх хуулба байгааг факсимиле-ээр хэвлэж судалгааны эргэлтэд оруулах зайлшгүй шаардлагатай байна.

Ном зүй

1. **Биеэр.** Биеэр дайлж өрнө умрын газрыг төвшитгэн тогтоосон бодлогын бичиг. ӨМСХХ. 1992
2. **Бира.** Ш.Бира Богд Жибзундамбын зохиосон “Цаг лугаа зохилдуулсан залбирал адистадын дээдийг хайрлагч орошибай” – Элбэг бүтээл. Профессор доктор Загчид сэцэнгийн наян насны ойд. ӨМҮХХ. 1996
3. **Диеэ Жо Харлоу.** Диеэ Жо Харлоу. Шинээр найруулсан монгол үндэстний товч түүх. ӨМАХХ. 1999
4. **Жамбадорж.** Жамбадорж Болор толь. Бээжин. 1984
5. **Коростовец.** Коростовец И.Я. От Чингис хана до Советской республики (Краткая история Монголии с особым учетом новейшего времени) УБ.2004
6. **Монгол.** Монгол үндэстний нэвтэрхий түүх. Бээжин. 1995
7. **Мункуев.** Мункуев Н.Ц. Эрдэни-дзу—Советская историческая энциклопедия Т.16.М.1976
8. **Ринчен Б.** Ринчен Б. Монгол бичгийн хэлний зүй. Тэргүүн дэвтэр. Удиртгал УБ.1964
9. **УТА.** Үндэсний төв архив
10. **Хатанбаатар.** Хатанбаатар Н. Найгал Ч. Эрдэнэ зуугийн түүх УБ.2005
11. **Шамба.** Шамба. Асрагч нэртийн түүх УБ.1960

Resume

The issues significant for the research into the history of Erdene-Zuu monastery, which is marked in history of Mongolian Buddhism many times, are considered in this article.

Some resources that directly relevant to the study of Ayush.A, a distinguished hero of western area of Khalkh Mongol, are discussed in this writing.